



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/2/СТА-ЗГТС

Баянхонгор 2020 он	Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 88089024 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: П.Амаржаргал Утас: 99890393 Цахим хаяг: amaraa_802002@yahoo.com Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын сүүрх сонгосон үндэслэл, тайлбар	6
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.13. Шилэн дансны мэдээлэл	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
Менежментийн захидал	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	11
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	11
1.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	11
1.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	12
1.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	13
1.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	13



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Ауд.02.27 № 1/169

танай _____-ны № _____-т

Г _____ Г

Аудитын гэрчилгээ

БАЯНХОНГОР АЙМГИЙН ХӨДӨЛМӨР
ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГИЙН
ТӨСВИЙН ЗАХИРАГЧД.АМАРСАНАА
ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\
005020114

болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

Аудитын тайлан

2.1. Оршил

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын дарга Д.Амарсанаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 23-наас 2020 оны 02 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Амаржаргал хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 16 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлж, тэдгээрийн хамрах хүрээ, санхүүжүүлэлтийг нэмэгдүүлж сангийн үйл ажиллагааг өргөжүүлэх" оршино.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагааны чиглэлийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг санхүүжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санг өргөжүүлэх гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна. Дараах хууль тогтоомжийг мөрдөж байна.

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Гүүк софт ХХК -ний” ХХК-ийн “Ахpoleг” программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 35 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн, материаллаг байдлын хувь хэмжээг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүнг 2019 оны 3 дугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн 321857,8 мянган төгрөгөөс тооцон 6437,1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1030256,3 мянган төгрөгөөр тооцон 20605,1 мянган төгрөгөөр тооцож үзсэнтэй холбоотой юм.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 414540,5 мянган төгрөгөөр буюу 1,9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлагын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөг/	
			Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1343512.66	1758053.16	414540.50
33	АВЛАГА	1343512.66	1758053.16	414540.50
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1343512.66	1758053.16	414540.50
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1343512.66	1758053.16	414540.50
51	Засгийн газрын хувь оролцоо	1343512.66	1758053.16	414540.50
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1343512.66	1758053.16	414540.50

Авлага дансны үлдэгдэл өссөн нь тайлант оны хөтөлбөрүүдийн санхүүгийн дэмжлэгтэй холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 1758053,16 мянган төгрөг болж 414540,5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгийн өөрчлөлттэй холбоотой байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь төвлөрүүлэх орлого байхгүй байна.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 72102 хөтөлбөрт зориулан 82616 /Засгийн газар хөдөлмөр эрхлэлтийг үндэсний зөвлөлийн тодорхойлсон хөтөлбөр, төсөл/, 80224 /Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс/-д зориулалттай 1240000,0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1240000,0 мянган төгрөгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас, 100000,0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, өмнөх оны эхний үлдэгдлээс 19771,1 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Зардлыг санхүүжүүлсэн орлогын гүйцэтгэлийг төлөвлөлттэй уялдуулан шалгахад:

Д/д	Үзүүлэлт	мян.төг			
		Төлөвлөгөө		Гүйцэтгэл	
		Хүн	Хөрөнгө	Хүн	Хөрөнгө
1	Орон нутгийн төсвөөс хуваарилсан санхүүжилт	0	0	0	100000.00
2	ХЭД сангаас хуваарилсан санхүүжилт	1304	1241127.60		1240000.00
3	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийн орлого	0	3427.20	7	4796.80
4	Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт			211	363774.77
5	Өмнөх оны үлдэгдэл буцаан олгосон санхүүжилт				19771.10
Нийт орлого		1304	1244554.80	218.00	1728342.67

Төсвийн нийт зардлын гүйцэтгэлийг тулгалт хийхэд:

Д/д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Ажил,мэргэжлийн чиг баримжаа олгох,зөвлөгөө өгөх үйлчилгээ	14,400.00	14,400.00
2	Ажилд зуучлах үйлчилгээ	10,500.00	10,282.50
3	Хөдөлмөрт бэлтгэх,хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр	31,385.00	29,555.00
4	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	488,140.00	478,448.00
5	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт,гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр	177,910.00	177,642.82
6	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	294,000.00	293,600.23
7	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	74,460.00	71,690.00
8	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	36,600.00	36,597.70
9	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл	4,000.00	4,000.00
10	Хөдөлмөрийн харилцаа,хөдөлмөрийн хүрээний суурь зарчим,үндсэн эрхийн хэрэгжилт	2,754.80	2,754.80
11	Бүртгэл мэдээллийн сүлжээ ажиллуулах	15,239.00	15,233.60
12	Хөдөлмөрийн салбарын ажилтнууд,ХНЗ-ийн 3 талт хорооны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хийгдэх чадавхи бэхжүүлэх сургалт	10,967.00	10,967.00
13	Сурталчилгаа,олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах	102,393.00	100,556.48
14	Хөтөлбөр төслийн хяналт,үнэлгээ	6,000.00	5,999.60
15	Гарын авлага,хэвлэмэл материал	3,552.00	3,552.00
16	Хүүхэд хамгаалагч төсөл	4,704.00	4,480.00
17	Илгээлтийн эзэн хөтөлбөр /Орон нутгийн төсвөөс/	-	100,000.00
	Дүн	1,277,004.80	1,359,759.73
	Улсын төсөвт төвлөрүүлсэн		11.42
	ХЭДТөв санд төвлөрүүлсэн		368,571.67
	Нийт		1,728,342.82

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 31 эрсдэлийг үнэлж гүйцэтгэх үе шатанд 10 эрсдэл тодорхойлж нийт 10 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 164481,0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 100000,0 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулга хийж, 154481,0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 заалт бүхий зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 100000,0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрч санхүүгийн тайланд залруулга хийлээ. Үүнд:

1. Аудитаар Баянхонгор аймгийн Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн А/264 тоот захирамжаар орон нутгийн төсвийн ангилагдаагүй зардлаас малжуулах хөтөлбөрт 100000,0 мянган төгрөгийн санхүүжилт олгосныг зориулалтын дагуу малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт зарцуулсан хэдий ч санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг санхүүгийн тайланд бүрэн тусгах”; 5 дугаар зүйлийн 5.1.4.-т “үнэн зөв байх, Иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулаг хийв

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал
Дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 137 мэдээллийг хугацаанд нь, 12 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	6	1	2
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	3	1	
4	Сар бүр	3	36	33	3	
5	Тухай бүр	8	96	96		
	Нийт	27	151	142	5	2

Төсвийн гүйцэтгэл/бүтэн жил, хагас жил, улирал бүр, сар бүр/, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ төлөвлөгөө, гүйцэтгэл, концесын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл /бүтэн жил, хагас жил, улирал бүр, сар бүр/, Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт /сар бүр/, Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар /улирал бүр/ 3-р улиралд, Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ /тухай бүр/ байршуулах мэдээллүүдийг 3-р сард хугацаа хоцроож мэдээлсэн байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт
Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг 2019 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 96 тоот албан бичгээр Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБООС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНБООС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Авлагын данстай холбоотой асуудал:

1.1. Илрүүлэлт: Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгийн хугацаа хэтэрсэн 147281,0 мянган төгрөгийн авлага байна.

Дээрх авлагын 64481,0 мянган төгрөг нь ХЭДСангаас санхүүжүүлсэн зээлийн эргэн төлөлтийн авлага, харин 82800,0 мянган төгрөг нь 2017, 2018 онуудад аймгийн Засаг даргын захирамжаар орон нутгийн ангилагдаагүй зардлаас санхүүжсэн 90,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн авлагын үлдэгдэл байна.

Зээлийн эргэн төлөлт хугацаандаа төлөгдөөгүй байгаа нь Баянхонгор аймгийн Засаг даргын 2017 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн А/345 тоот захирамжийн хавсралт "Баянхонгор аймгийн малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих" журмын 4.1.6-т зааснаар "Санхүүгийн дэмжлэгээр мал худалдан авч өгснөөс хойш 2 жилийн дараа эргүүлэн 100 хувь эргүүлэн төлнө" гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2. Эрсдэл: Сангийн хөрөнгийн үр ашиг гарахгүй царцмал байдалд орох.

1.3. Өгсөн зөвлөмж: Холбогдох журам, гэрээний дагуу санд төвлөрүүлээгүй Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн 147281,0 мянган төгрөгийн авлагын барагдуулах ажлын зохион байгуулах төлөвлөгөө гарган ажиллаж, авлагын бүрэн барагдуулах..

2.1. Илрүүлэлт: Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн орон нутгаас санхүүжсэн 190000,0 мянган төгрөгийн зээлийн эргэн төлөлтөөс санд төлөгдсөн 7200,0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй, дээд шатны байгууллагын төсөвт төвлөрүүлсэн байна.

2.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгийн үр ашиг гарахгүй байх.

2.3. Өгсөн зөвлөмж: Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт зориулан орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилтийн эргэн төлөлтийн 7200,0 мянган төгрөгийн орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлж, цаашид орсон орлогыг тухай бүр нь төвлөрүүлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1343512664.00	1758053163.00
33	АВЛАГА	1343512664.00	1758053163.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	19771150.00	11420.00
33400	Зээлийн хүүгийн авлага	0.00	24075000.00
335	Бусад авлага	1323741514.00	1733966743.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1323741514.00	1733966743.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1343512664.00	1758053163.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1343512664.00	1758053163.00
51	Засгийн газрын хувь оролцоо	1343512664.00	1758053163.00
512	Хуримтлагдсан үр дүн	1343512664.00	1758053163.00
51210	Өмнөх үеийн үр дүн	759515229.00	1343512664.00
51220	Тайлант үеийн үр дүн	583997435.00	414540499.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1343512664.00	1758053163.00

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1156356000.00	1344796895.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	102856000.00	104796895.00
120	Нийтлэг татварын бус орлого	2856000.00	4796895.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2856000.00	4796895.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2856000.00	4796895.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	100000000.00	100000000.00
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	100000000.00	100000000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1053500000.00	1240000000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1053500000.00	1240000000.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	1053500000.00	1240000000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	572358565.00	930256396.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	572358565.00	930256396.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4000000.00	4000000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4000000.00	4000000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4000000.00	4000000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	568358565.00	926256396.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	326974565.00	581759730.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	326974565.00	581759730.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	4796895.00

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		4796895.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	241384000.00	339699771.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	241384000.00	339699771.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	583997435.00	414540499.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	583997435.00	414540499.00

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1399129715.00	1728342816.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	345629715.00	468571666.00
120	Нийтлэг татварын бус орлого	245629715.00	368571666.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	245629715.00	368571666.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	242773715.00	363774771.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2856000.00	4796895.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	100000000.00	100000000.00
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	100000000.00	100000000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1053500000.00	1259771150.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1053500000.00	1259771150.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	1053500000.00	1240000000.00
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	0.00	19771150.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1399129715.00	1728342816.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1399129715.00	1728342816.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4000000.00	4000000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4000000.00	4000000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4000000.00	4000000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1395129715.00	1724342816.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1133974565.00	1355759730.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1133974565.00	1355759730.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	4796895.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		4796895.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	15525435.00	11420.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	15525435.00	11420.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	245629715.00	363774771.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	245629715.00	363774771.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	1,343,512,664.00	1,343,512,664.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	1,343,512,664.00	1,343,512,664.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн				0.00
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	1,343,512,664.00	1,343,512,664.00
D01	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	1,343,512,664.00	1,343,512,664.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	1,343,512,664.00	1,343,512,664.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	414,540,499.00	414,540,499.00
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	1,758,053,163.00	1,758,053,163.00

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1277004800.00	1359759730.00	82754930.00	106.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1277004800.00	1359759730.00	82754930.00	106.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4000000.00	4000000.00	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4000000.00	4000000.00	0.00	100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4000000.00	4000000.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1273004800.00	1355759730.00	82754930.00	106.50

2132	Бусад урсгал шилжүүлэг	1273004800.00	1355759730.00	82754930.00	-	106.50
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1273004800.00	1355759730.00	82754930.00	-	106.50
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1273004800.00	1355759730.00	82754930.00	-	106.50
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1273004800.00	1355759730.00	82754930.00	-	106.50
131001	Улсын төсвөөс санхүүжих	1273004800.00	1355759730.00	82754930.00	-	106.50

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:


АУДИТОР:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



П.АМАРЖАРГАЛ

А.ЦЭЭНЯМ

Б.МӨНХБАТ